

МУИС-ХШУИС-ийн Хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн тэнхимийн Хөтөлбөрийн дэд хорооны хурлын протокол (№4)

Хугацаа:

Хурал 2020 оны 06-р сарын 04-ний өдрийн 15:00 цагт эхэлж 16:00 цагт дуусав.

Ирц:

Хуралд тэнхимийн эрхлэгч, профессор Ч.Сономдагва, профессор О.Алтансүх, Б.Батхүү, дэд профессор Ц.Соёл-Эрдэнэ, ахлах багш Н.Оюунчимэг нар оролцов. Хөтөлбөрийн дэд хорооны ирц 100% байв.

Байршил:

Хурал МУИС-ийн хичээлийн 3а байрны 217 тоот өрөөнд болов.

Хэлэлцэх асуудал:

1. Магистр, докторын хичээлд оногдох багц цагийг бууруулж тооцох тухай
2. МУИС-ийн ХЕХ-оос томилогдсон ажлын хэсгээс ХШУИС-ийн ХБООИТ-ийн БОХТ, ХБОИ, ХБОС хөтөлбөрүүдийн талаар гаргасан дүгнэлтийн тухай
3. INTENSE төслийн хүрээнд боловсруулсан хичээлийн тодорхойлолт, ХБОС-ын сургалтын төлөвлөгөөний тухай

Хурлын явц:

Ч.Сономдагва: Өнөөдрийн хурлаар манай тэнхимийн хөтөлбөрүүдийн талаарх ажлын хэсгийн дүгнэлтийн талаар авч хэлэлцэн, тодорхой саналуудыг ХЕХ-ны хуралд хүргүүлэх асуудлыг ярилцана. Энэ асуудлын хүрээнд, хэрэв БОХТ хөтөлбөр хаагдвал тэнхимийн багш нарын цагийн асуудал үүсэх учраас 2020-2021 оны хичээлийн жилд БАХҮ (Байгаль ашиглалт, хяналт үнэлгээ) хөтөлбөрөөр элсэлт авах асуудлыг хэлэлцэж, ХЕХ-д хүсэлт хүргүүлэх саналыг оруулж байна. (Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтсийн дарга Н.Пүрэвцогтоос асууж, зөвлөгөө авсны дагуу)

Үүнээс гадна, магистр, докторын хичээлд оногдох багц цагийг бууруулж тооцох тухай 2019 оны 12 сард Б.Очирхуяг захирлын гаргасан тушаалыг улирал дамнан тооцуулалгүй, зөвхөн намрын улиралд нь тооцуулья гэдэг дээр санал хурааж, хэрэв дэмжигдвэл Сургалт, оюутан хариуцсан дэд захирал Д.Бадмаанямбууд хүсэлт илгээх асуудлыг шийдвэрлэх шаардлага гарлаа. Энэ асуудал дээр мөн санал хураана.

БАХҮ-ний хөтөлбөр нь түр царцаагдаад байсан бөгөөд шууд элсэлт авах боломжтой. Энэ талаар Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтсийн дарга Н.Пүрэвцогтоос асууж тодруулахад, магадлан итгэмжлэлээр оролгүйгээр энэ намар шууд элсэлт авах боломжтой гэдгийг хэлсэн.

За ингээд эхний асуудлын тухайд саналаа хэлнэ үү. Дээр дурдсан тушаалын хэрэгжилтийг зөвхөн намрын улиралд тооцуулья гэсэн хүсэлтийг Сургалт, оюутан хариуцсан дэд захирал Д.Бадмаанямбууд илгээх үү? ТХДХ-ны 100 хувийн саналаар дэмжигдлээ.

Өнөөдрийн хурлаар хэлэлцэх хоёр дахь асуудлын талаар одоо саналаа хэлнэ үү.

О.Алтансүх: БОХТ хөтөлбөрөөр элсэлт авахгүй гэсэн шийдвэр одоогоор гараагүй байгаа ч ер нь гарах нь ойлгомжтой болж байх шиг байна. Тиймээс энэ намар БАХҮ хөтөлбөрөөр элсэлт авах нь зүйтэй гэж бодож байна. Уг хөтөлбөрт МУИС-ийн 2017 оны А/52 тоот тушаалаар 4 жилийн хугацаатай тусгай зөвшөөрөл өгсөн байдаг. Тэгэхээр 2020-2021 оны хичээлийн жилд тус хөтөлбөрөөр элсэлт авахад асуудалгүй гэж бодож байна.

Мөн ХБОИ хөтөлбөрийг анх боловсруулж байхад БОХТ хөтөлбөрийн хичээлээс оруулж байсан. Өөрөөр хэлбэл, дээрх хоёр хөтөлбөрт холилдсон хичээлүүд бий. Тиймээс энэ асуудлыг тэнхим дээрээ ярилцаж хичээлүүдээ цэгцэлье гэсэн бодолтой байна.

Ц.Соёл-Эрдэнэ: ХБОИ хөтөлбөр хэрэгжээд дөнгөж 2 дахь жилдээ явж байна. Мэргэжлийн хичээлүүд орж эхлээгүй байна. Хоёр жилийн дараа л энэ хөтөлбөрт жижиг өөрчлөлт хийх боломжтой. Би энэ чиглэлээр БНСУ-д бакалаврын түвшнээс нь суралцаж төгссөн хүний хувьд тус хөтөлбөрийг маш сайн харьцуулалт хийж, бүтэн 2 жилийн хугацаанд боловсруулсан. Тиймээс маш сайн болсон гэж бодож байна. Мөн энэ хөтөлбөр дээр үндэсний хэмжээний мэргэжлийн шинжээч ажилласан. Багш нарын цагийн ачааллын тухайд, тэнхимийн багш нарын зааж буй хичээлүүд өөр байгаа тул мэргэжлийн хүмүүсийг бүрдүүлэх санаатай байна.

Ажлын хэсгийн дүгнэлт дээр ХБОИ хөтөлбөрийг БОХТ хөтөлбөртэй уялдуулах талаар юу ч дурдаагүй атал яагаад заавал энэ хоёр хөтөлбөрийг уялдуулах тухай яриад, хурлын хэлэлцүүлэх асуудалд байхгүй зүйлийг зохиомлоор нэмж оруулаад байгаа юм бэ?

Ч.Сономдагва: ХБОИ бол агаар, ус, хөрс гэх мэтчилэн байгаль орчны асуудал ярих ёстой. Гэтэл яагаад байгаль орчны хичээлүүд байхгүй, эрээвэр хураавар янз бүрийн хичээлүүд голлоод байгаа юм бэ? Байгаль орчны хичээлүүдийг оруулах хэрэгтэй шүү дээ.

Одоо гол асуудал дээрээ санал хураая. 2020-2021 оны хичээлийн жилээс БАХУ хөтөлбөрөөр бакалаврын түвшний элсэлт авахыг дэмжиж байна уу?

ХБООИТ-ийн ХДХ-ны 100 хувийн саналаар дэмжигдлээ.

Н.Батхүү: БОХТ хөтөлбөр хаагдах нь тодорхой болж байгаа юм байна гэж ойлголоо. Тэгэхээр ХБОИ, БОХТ хөтөлбөрүүдийн хичээлүүдийг цэгцлээд явахад болохгүй юм байхгүй гэж бодож байна. Тэгээд энэ намраас БАХУ хөтөлбөрөөр элсэлтээ аваад явахад асуудалгүй юм чинь энэ хүсэлтээ ХЕХ-д гаргаад явбал яасан юм бэ?

Ц.Соёл-Эрдэнэ: Хүсэлтээ гаргахдаа бас гаднын бусад сургуулиудтай харьцуулаад, үндэслэлээ сайн гаргаад өгөх хэрэгтэй байх. ХЕХ үндэслэл шаардах байх гэж бодож байна.

О.Алтансүх: Ажлын хэсгийн дүгнэлттэй холбоотой нэмж хэлэх зүйл байна. Уг дүгнэлтэд ХБОС хөтөлбөрийг өөр сургуульд шилжүүлэх тухай тусгагдсаныг та бүхэн мэдэж байгаа. Энэ талаар би холбогдох хүнээс нь асууж тодруулахад ХБОС нь хэрэглээний шинжлэх ухааны салбар дундын хөтөлбөр мөн гэдгийг батлах, дэлхийн шилдэг 100 сургуулийн бүтцийн хувьд аль сургуульд харьяалагдаж байгааг харах, pure science нь юу болохыг тогтоох хэрэгтэй гэсэн. Үүний дагуу ажиллаж байна. Дээрх 100 сургуулийн 51-д нь хайлт хийж үзэхэд ХБОС хөтөлбөр нь хэрэглээний шинжлэх ухааны салбар дундын хөтөлбөр мөн гэдгийг батлах хангалттай дүн гарсны зэрэгцээ бүтцийн хувьд нэг бол хэрэглээний шинжлэх ухаан-инженерчлэлийн бүрэлдэхүүнд эсвэл хэрэглээний шинжлэх ухааны бүрэлдэхүүнд эсвэл салбар дундын сургуулийн бүрэлдэхүүнд харьяалагдаж байна. Жишээ нь Харвардын их сургуульд Хүрээлэн буй орчин судлал хөтөлбөр нь Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуульд харьяалагдаж байна. <https://www.seas.harvard.edu/> Хэрэглээний химийн үндсэн шинжлэх ухаан нь хими, Хэрэглээний математик бол математик байдагтай адил Хүрээлэн буй орчин судлалын үндэслэх шинжлэх ухааны салбар нь нэг биш олон буюу хими, физик, экологи, газарзүй байдаг. Иймээс ХБОС хөтөлбөрийн бүрэлдэхүүн сургуулийн суурийг хөтөлбөрийн сууриар солихдоо эдгээр шинжлэх ухаануудтай холбоотой хичээлүүдийг оруулах нь хэрэгтэй. Үүнээс гадна, МУИС-ийн УЗ-ийн 2013 оны 03-р тогтоолд хэрэглээний ухааны чиглэлийн нэгжтэй байхыг заасан байдаг. Хүрээлэн буй орчин судлал нь экологи, хими, физик, газарзүй гэсэн шинжлэх ухаанууд дээр суурилсан салбар дундын, хэрэглээний шинжлэх ухаан мөн тул МУИС-д УЗ-ийн тогтоолын дагуу байгуулагдсан ХШУИС гэж байгаа тохиолдолд түүнд харьяалагдаж явах нь зүйтэй. Мөн INTENSE төслийн хүрээнд шинэчилсэн хичээлийн хөтөлбөрүүдийг танилцуулав. Түүнчлэн 2 жилийн өмнө шахуу Баярмагнай сургалт хариуцсан дарга байх үед бүрэлдэхүүн сургуулийн суурийг хөтөлбөрийн сууриар солих тухай шийдвэр гарсан бөгөөд үүнийг манай

тэнхим өнөөг хүртэл хэрэгжүүлээгүй байгаа тул тэнхимийн бүх хөтөлбөрүүдийг 2020-2021 оны хичээлийн жилдээ багтааж шинэчлэх шаардлагатай.

Шийдвэрлэсэн нь:

1. Магистр, докторын хичээлд оногдох багц цагийг бууруулж тооцох тухай МУИС-ийн захирал Б.Очирхуягийн 2019 оны 12 сарын тушаалыг зөвхөн намрын улиралд нь тооцуулах тухай хүсэлтийг Сургалт, оюутан хариуцсан дэд захирал Д.Бадмаанямбууд хүргүүлэх
2. 2020-2021 оны хичээлийн жилд 071203 индекстэй Байгаль Ашиглалт Хяналт Үнэлгээ хөтөлбөрөөр бакалаврын түвшинд элсэлт авах хүсэлтийг ХЕХ-оор хүргүүлэх
3. Хүрээлэн буй орчин судлал нь экологи, хими, физик, газарзүй гэсэн шинжлэх ухаанууд дээр суурилсан салбар дундын, хэрэглээний шинжлэх ухаан мөн, түүнчлэн дэлхийн шилдэг 100 сургуулиудын хувьд ХБОС нь хэрэглээний шинжлэх ухааны бүрэлдэхүүнд эсвэл салбар дундын сургуулийн бүрэлдэхүүнд харьяалагдаж байдаг тул МУИС-д УЗ-ийн тогтоолын дагуу байгуулагдсан ХШУИС гэж байгаа тохиолдолд түүнд харьяалагдаж явах нь зүйтэй болохыг, INTENSE төслийн хүрээнд боловсруулсан хичээлийн төлөвлөгөөнүүдийг тэнхимийн хэмжээнд дэмжих, сургалтын төлөвлөгөөг ХЕХ-ны хуралд профессор О.Алтансүх танилцуулах

Протокол хөтөлсөн:

Хөтөлбөрийн дэд хорооны н.б.д.



доктор Н.Оюунчимэг

Хянасан:

Хөтөлбөрийн дэд хорооны ахлагч



профессор Ч.Сономдагва